

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/18.

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 350 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах" жил болгон зарлах тухай 07/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах" зорилтот жилийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр шинэ санал санаачлага гарган ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгийн дарга, захирал нарт тус тус даалгасугай.

3. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 11 дугаар сарын 10
өдрийн 4/18 дугаар тушаалын
100 нэгдүгээр хавсралт

**“НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ-ОРЧНЫ
БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Я.Жаргал -Эрүүл мэндийн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Валя -Эрүүл мэндийн газрын Захиргаа, санхүү, нийтлэг үйлчилгээний албаны дарга

М.Ганцэцэг -Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

Б.Оюунчимэг -Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Б.Одонтуяа -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сургалтын менежер

Ж.Аюуш -Ариун санаа эмнэлгийн “Гантиг” шүдний эмнэлгийн менежер

-оОо-

Эрүүл мэндийн газрын
даргын 2022 оны 05 дугаар
сарын 10 өдрийн 418 дугаар
тушаалын хөёрдугаар
хавсралт

**“НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ-ОРЧНЫ
БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр				
1	“Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах	2022 оны 05-р сарын 20-ны дотор	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
2	Болзолт уралдааны удирдамж боловсруулж, батлуулах, шинэ санаа, шилдэг бүтээлийн уралдаан зохион байгуулах	Жилдээ	ЭМГ, Ариунсанаа ХХЭ	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлэг
3	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 3-аас доошгүй ажлыг шинээр санаачлан хэрэгжүүлэх	Жилийн турш	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймаг, сумдын ЗДТГ, БОАЖГ, бусад мэргэжлийн байгууллага
4	Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, алба хаагчдад мод тарих, үржүүлэх, арга аргачлал техникийн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	2022 оны 05-20-с 2022 оны 06-р сарын 20 хүртэл	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймгийн ЗДТГ, БОАЖГ
5	Аймгийн хэмжээнд зохион байгуулах их цэвэрлэгээ, мод тарих аян, арга хэмжээнд алба хаагч бүрийг идэвхитэй оролцуулан, хамтран ажиллах	Тухай бүр	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
6	Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэлд шаардлагатай төсвийг гаргаж төлөвлөгөөнд тусгах	Жилдээ	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
7	“Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн	Тухай бүр	Зорилтот жилийн ажлын хэсэг	Аймгийн БОАЖГ

	ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах			
8	Зорилтот жилийн хүрээнд хийж, хэрэгжүүлсэн ажлын тайланг бичиж, Эрүүл мэндийн газарт ирүүлэх	2022 оны 12 дугаар сарын 10-ны дотор	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр				
9	Өөрийн эзэмшлийн гадна орчин, зам, талбай, гудамжны ногоон байгууламжийн хэсгийг зүлэгжүүлэх, шинээр модны суулгац, суулгах цэцгийн мандал хийж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2022 оны 05 дугаар сарын 15-с 10 дугаар сарын 15 хүртэл	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймгийн БОАЖГ, Зорилтот жилийн ажлын хэсэг
10	Зөвшөөрөгдсөн нийтийн эзэмшлийн гудамж, талбай, улсын чанартай авто замын дагуу мод тарих ажлыг санаачлан зохион байгуулах	2022 оны 05 дугаар сарын 15-с 10 дугаар сарын 15 хүртэл	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймгийн БОАЖГ, Зорилтот жилийн ажлын хэсэг
11	Ногоон байгууламж байгуулах зураг төсөл, төсвийн тооцоог нарийвчлан гаргаж, мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж, ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж мод тарих ажлыг зохион байгуулах	2022 оны 05 дугаар сарын 15-с 10 дугаар сарын 15 хүртэл	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймгийн БОАЖГ, Зорилтот жилийн ажлын хэсэг
12	Модны арчилгаа болон хавар, намрын цэнэг, зуны усалгааны ажлуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэх	2022 оны 05 дугаар сарын 15-с 10 дугаар сарын 15	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, Зорилтот жилийн ажлын хэсэг
13	Гэр хороололд амьдардаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад байгууллагын төсвөөс болон өөрсдийн хөрөнгөөр хувийн эзэмшлийн хашаанд мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах	2022 оны 05 дугаар сарын 15-с 10 дугаар сарын 15	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр				
14	Сард 1 удаа нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж байгууллагын дотоод, гадаад орчин, нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдал, хатсан өвсийг цэвэрлэх ажлыг зохион байгуулах	Сар бүрийн 2 дахь долоо хоногийн пүрэв гаригт	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймаг, сумын ЗДТГ, БОАЖГ
15	Ажлын онцлогоос хамаарч гадаа байнга ажилладаг замын цагдаа, хот тохижилт үйлчилгээний ажилтан,	2022 оны 05 дугаар сарын 15-с 10 дугаар	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв,	Зорилтот жилийн ажлын хэсэг

	шатахуун түгээх станцын түгээгч зэрэг ажилтнуудад эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, үзлэг шинжилгээнд хамруулах	сарын 15 хүртэл	Хувийн хэвшлийн эмнэлэг	
16	Агаар, орчны бохирдол, ундны усны чанар, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хийх	2022 оны 07 дугаар сарын 20-с 09-р сарын 20 хүртэл	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
17	Ус хангагч байгууллагад ус, ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуйн талаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах	2022 оны 06 сар 2022 09 сар	ЭМГ, БОАЖГ, ОУСУГ	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг
18	Эмнэлгийн хог, хаягдлын менежментийн талаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтан болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудад ажлын байрны сургалтыг тасралтгүй зохион байгуулах	Тухай бүр	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	ЭМЯ, НЭМҮТ, ХӨСҮТ
19	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээллийг тогтмол авах мэдээллийн сан бүрдүүлж, дээд шатлалын байгууллагад мэдээлэх	Сар бүр	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	ЭМГ
20	Эрүүл мэндийн байгууллагын эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох олон талт арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	ЭМГ, ХӨСҮТ
21	Эрүүл мэндийн байгууллагуудын ундны ус, ариун цэврийн байгууламжийн нэгдсэн судалгааг гаргаж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох	2022 оны 05-р сарын 10-15 хооронд	Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг
22	Даавуун уутыг нийтийн хэрэглээнд хэвшүүлэх аян зохион байгуулж ажиллах	Жилдээ	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	ЭМГ, зорилтот жилийн ажлын хэсэг, БОАЖГ
Иргэд олон нийтэд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиглэлээр				
23	Хүн амд ундны усны чанар, аюулгүй байдал болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр	2022 оны 05-09 сар хүртэл	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	ЭМГ, БОАЖГ

	сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах			
24	Дам тамхидалт, электрон тамхины хор уршгийн талаар иргэдэд зориулсан сургалт, зөвлөмж, сурталчилгааны материал боловсруулан түгээх	Жилдээ	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг
25	Иргэдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, постер, гарын авлага бэлтгэн олшруулж, түгээх	Жилдээ	ЭМГ, БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Аймгийн БОАЖГ
26	Зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудыг цахим орчиноор дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх	Тухай бүр	БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн эмнэлэг	Зорилтот жилийн ажлын хэсэг